



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

Г Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг
бүртгэх тухай.

Мянганы хөгжлийн 4, 5 дахь зорилтод хүрэх, "Эх, нярайн эрүүл мэнд 2011- 2015" стратегийн 3.15 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь.

1. "Эхийн эндэгдлийг тооцох, бүртгэх, мэдээлэх журам"-ыг нэгдүгээр, "Жирэмсэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийг бүртгэх, мэдээлэх журам"-ыг хоёрдугаар, "Жирэмсэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийг бүртгэх маяг"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эхийн эндэгдлийн тохиолдлыг сар бүрийн статистик мэдээллээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Эрүүл мэндийн газарт мэдээлэх; эх эндсэн тохиолдлын материалыг нэг сарын дотор, жирэмсэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийн тохиолдлын материалыг дараа улирлын эхний сарын 05-ны дотор бүрдүүлэн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд албан тоотоор тогтмол хүргэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга наарт үүрэг болгосугай.
3. Эхийн нас барагт, ноцтой хүндрэлийн тохиолдол бүрийг нягтлан судалж, дунг Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн хуралд тухайн жилийн хагас, бүтэн жилээр хэлэлцүүлэх, сургамж зөвлөмжийг тусгасан товхимлыг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан хэвлүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад түгээж байхыг Эмнэлгийн тусlamжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Гончигсүрэн), Мэдээлэл, хяналт - шинжилгээ, үнэлгээний газар (Д.Жаргалсайхан), Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Эрүүл мэндийн газар (Ш.Энхбат), Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Энхтөр) наарт даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2005 оны 190 дүгээр тушаалтыг хүчингүйд тооцсугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд (Ж.Цолмон)-д үүрэг болгосугай.

САЙД

Н.ХҮРЭЛБААТАР

080778

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 7 дугаар сарын
6-ны өдрийн 144 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭХИЙН ЭНДЭГДЛИЙГ ТООЦОХ, БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Тодорхойлолт

1.2. Эмэгтэй, жирэмсний хугацаанд болон төрөх үедээ, эсвэл жирэмсэлт шийдвэрлэгдсэнээс хойш 42 хоногийн дотор жирэмсний байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмсэн, төрөлт болон түүнийг удирдахтай холбогдож хүндэрсэн ямар нэгэн шалтгаанаар нас барахыг "Эхийн нас баралт/эндэгдэл" гэнэ.

Эх барихын ба эрхтэн тогтолцооны эмгэгүүд, эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд хийгдсэн үр хөндөлт, зулбалт, умайн гаднах жирэмсний улмаас нас барах тохиолдол эхийн эндэгдэлд орно. Золгүй тохиолдлын* шалтгаантай нас баралтыг эхийн эндэгдэлд оруулахгүй.

Эхийн эндэгдлийг 100000 амьд төрөлтөнд харьцуулан доорх томьёог ашиглан тооцно.

Жирэмсэн, төрөлт үед болон жирэмсэн

Эхийн эндэгдлийн харьцаа = шийдвэрлэгдсэнээс хойш 42 хоногт эндсэн эхийн тоо x 100000

Амьд төрөлтийн тоо

Эхийн эндэгдлийн индекс нь тусlamжийн чанарыг илтгэсэн чухал үзүүлэлт юм. Үүнийг дараах томьёогоор тооцно. Ноцтой хүндрэлийн тохиолдол гэдэгт эхийн эндэгдэл, жирэмсэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийг хамруулна. /ЭЭ+ ЭНХ/

$$\text{ЭЭИ} = \frac{\text{ЭЭ}}{\text{ЭЭ} + \text{ЭНХ}} \times 100$$

ЭЭИ- Эхийн эндэгдлийн индекс

ЭЭ- Эхийн эндэгдлийн тоо

ЭНХ-Эхийн ноцтой хүндрэл

Хоёр. Эхийн эндэгдлийн ангилал

2.1. Эхийн эндэгдлийг шалтгаанаар нь эх барихын шууд, эх барихын бус шалтгаантай гэж хоёр ангилна.

2.1.1. Эх барихын шууд шалтгаантай эндэгдэлд жирэмсэн, төрөх, төрсний дараах үед тэдгээртэй холбоотой хүндрэлүүдээс шалтгаалсан нас баралт хамаарна. Тухайлбал; Цус алдалт (ихэвчлэн төрсний дараах үеийн), үжил, манас таталт, төрөлтийн саатал, аюултай үр хөндөлтийн хүндрэл болон эдгээрийн үед хийгдсэн ажилбар, эмчилгээний арга

барилаас үүдсэн болон алдаанаас алдаанд дамжсан хүндрэлээс үүдэлтэй нас баралт хамаарна.

2.1.2. Эх барихын бус шалтгаантай эндэгдэл нь жирэмслэхээс өмнө өвчилж байсан эмгэг, эсвэл тухайн жирэмсний явцад шинээр үүссэн өвчинүүд (гэхдээ эх барихын шууд шалтгаангүйгээр) жирэмсний нөлөөгөөр хүндэрсний улмаас эндэх явдал юм. Тухайлбал: Сүрьеэ, цус багадалт, зүрх судасны өвчинүүд, ХДХВ/ДОХ гэх мэт.

Гурав. Бүртгэх, мэдээлэх, хэлэлцэх

3.1. Эх эндсэн тохиолдол бүрт аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн захиргаанд 24 цагийн дотор мэдэгдэж, газар дээр нь холбогдох эмч нарыг байлцуулан эмгэг судлалын шинжилгээг хийнэ. Эмгэг судлаач эмч тухайн тохиолдолтой холбоотой бүх баримттай танилцаж, эмгэг судлалын шинжилгээний дүгнэлтийг 14 хоногийн дотор гаргаж, холбогдох эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ.

3.2. Эх гэртээ нас барсан тохиолдолд өрх, сумын эмч нь эндсэн эхийн гэр бүлийн гишүүд, холбогдох бусад хүмүүстэй харилцан ярилцаж, угээр шинжих аргаар эхийн эндэгдлийн шалтгаан, нөлөөлсөн байж болох **нийгмийн болон амьдрал ахуйн хүчин зүйлийн** талаар судалж, эхийн эндэгдлийн судалгааны картанд хавсаргана.

3.3. Тухайн эмнэлгийн дарга, эмнэлгийн чанарын менежер, эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмч нь холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтран эх эндсэнээс хойш 21 хоногт багтаан тухайн тохиолдлын холбогдох материалтай танилцаж, эхийн эндэгдлийг судлах байгууллагад сууринласан болон эмнэлзүйн хяналтын аргуудаар доорх асуудлыг хэлэлцэнэ:

- Тухайн тохиолдол нь эхийн эндэгдэл мөн эсэхийг нягтална;
- Эхийн эндэгдлийн ямар ангилалд хамарагдахийг нягтална;
- Эхийн эндэгдлийн шалтгааныг тогтооно;
- Эхийн эндэгдэлд нөлөөлсөн хожимдлыг тодорхойлно;
- Уг хожимдлыг арилгахаар хэрэгжүүлэх ажлын талаар шийдвэр гаргана;
- Оролцогчид харилцан ярилцаж, санал гаргана;
- Оношлогоо, эмчилгээтэй холбоотой сургамж, дүгнэлтийг хийнэ;
- Оношийн зөрөө байсан эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ;
- Эхийн эндэгдлийг бүртгэх маягтыг хамтран бөглөнө;
- Хурлаас зөвлөмж, шийдвэр гаргана;
- Гарсан сургамж, зөвлөмж, шийдвэрийг холбогдох байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулна.
- Эхийн эндэгдлийн тохиолдлын холбогдох бүх материалыг хувилан, хурлын зөвлөмж, шийдвэрийн хамт харьяа Эрүүл мэндийн газарт хурлаас хойш ажлын 3 хоног дотор хүргэнэ.

3.4. Эрүүл мэндийн газрын эхийн эндэгдлийн тохиолдлыг хэлэлцэх баг эх эндсэн тохиолдлын холбогдох баримтуудыг нягтлан судалж, нотолгоонд тулгуурлан зөвхөн бүрэлдэхүүнээрээ дараах асуудлыг шийдвэрлэнэ:

- Сургамжинд тулгуурлан орон нутгийн түвшинд эхийн эндэгдлийг дахин гаргахгүй байх чиглэлээр үйл ажиллагааны чиглэлийг тогтоож, шийдвэр гаргана;
- Өмнө гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг үнэлнэ.

3.5. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эх эндсэнээс хойш нэг сарын дотор эхийн эндэгдлийн тохиолдлын бүх материалын хуулбар, эхийн эндэгдлийг хэлэлцэх багийн хурлын шийдвэрийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд албан тоотоор ирүүлнэ.

3.6. Эхийн эндэгдлийг тохиолдлыг сар бүрийн статистик мэдээллийн хамт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Эрүүл мэндийн газарт мэдээлнэ.

3.7. Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн яамны эх барих эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран эхийн эндэгдлийн тохиолдолд дүн шинжилгээ хийж, Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн хурлаар дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан хэлэлцүүлнэ.

Дөрөв. Эхийн эндэгдлийг хэлэлцэх багийн бүрэлдэхүүн

4.1. Нийслэлд;

Зөвлөлийн дарга	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга
Нарийн бичгийн дарга	Эх барих, эмэгтэйчүүдийн тусlamж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	<p>Нийслэлийн Эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн</p> <p>Эх барих эмэгтэйчүүдийн мэргэжлийн нийгэмлэгийн төлөөлөл</p> <p>Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн</p> <p>Эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн</p> <p>Шаардлагатай тохиолдолд нийслэлийн дотрын болон бусад мэргэжлийн ерөнхий мэргэжилтэн</p>

4.1.2. Аймагт;

Зөвлөлийн дарга	Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
Нарийн бичгийн дарга	Эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмч
Гишүүд:	<p>Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, эсвэл Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусlamж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга</p> <p>Аймгийн ЭМГ-ын эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн</p> <p>Эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн</p> <p>Шаардлагатай тохиолдолд аймгийн дотрын болон бусад мэргэжлийн ерөнхий мэргэжилтэн</p>

**ЖИРЭМСЭЛТ, ТӨРӨЛТ, ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН НОЦТОЙ ХҮНДРЭЛИЙГ БҮРТГЭХ,
МЭДЭЭЛЭХ ЖУРАМ**

Нэг. Тодорхойлолт

1.1. Эмэгтэй, жирэмсний хугацаанд болон төрөх үедээ, эсвэл жирэмсэлт шийдвэрлэгдсэнээс хойш 42 хоногийн дотор эхийн амь насанд аюул учирч аврагдсан эмэгтэй “Жирэмсэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэл” гэж тооцно.

1.2. Жирэмсэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийг дараах шалгуур үзүүлэлтээр бүртгэнэ.

Зүрх, судасны үйл ажиллагааны алдагдал	<ul style="list-style-type: none"> Шок Судас нарийсгагч эм үргэлжлүүлэн хэрэглэх Зүрх зогсох Хүнд хэлбэрийн гипоперфузи (лактат >5 ммоль/Л эсвэл >45 мг/дЛ) Хүнд хэлбэрийн хүчилшил (pH<7.1)
Амьсгалын үйл ажиллагааны алдагдал	<ul style="list-style-type: none"> Цочмог хөхрөлт Таталдсан амьсгал /ухлийн өмнөх амьсгал/ Амьсгал хэт олшрох (амьсгалын тоо>40 мин) Амьсгал хэт цөөрөх (амьсгалын тоо<6 мин) Хүнд хэлбэрийн гипоксеми ($\text{PaO}_2/\text{FiO}_2 < 200$ эсвэл O_2-ийн ханамж 60 минутаас дээш хугацаанд 90%-с бага байх) Мэдээгүйжүүлэгтэй холбоогүйгээр цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавьж амьсгалуулах
Бөөрний үйл ажиллагааны алдагдал	<ul style="list-style-type: none"> Шингэн сэлбэлт/шээс хөөх эмчилгээнд үр дүнгүй олигоурия Бөөрний цочмог дутагдалын үед диализ хийсэн Цочмог хүнд хэлбэрийн азотеми (креатинин >300ммоль/мл эсвэл 3,5мг/дл буюу түүнээс их)
Бүлэгнэлт/гематологийн алдагдал	<ul style="list-style-type: none"> Бүлэн үүсэхгүй байх Цус эсвэл улаан эс их хэмжээгээр сэлбэх (5 нэгжээс дээш) Цочмог, хүнд хэлбэрийн ялтын цөөрөл (50000 ялтас/мл-с бага)
Элэгний үйл ажиллагааны алдагдал	<ul style="list-style-type: none"> Манас таталтын урьдалтай үед шарлах Цочмог хүнд хэлбэрийн гипербилирубинеми (билирубин 100 ммоль/л-с эсвэл 6,0 мг/дл-с их)
Мэдрэлийн үйл ажиллагааны алдагдал	<ul style="list-style-type: none"> Удаан хугацаагаар ухаангүй байх (12 цаг болон түүнээс дээш хугацаагаар үргэлжилсэн /дүгжраа/ бодисын солилцооны дүгжрааг оролцуулна) Цус харвалт Эпилепсийн байдал / хянаж чадахгүй байгаа таталт Бүтэн саажил
Умайн үйл ажиллагааны алдагдал	<ul style="list-style-type: none"> Умайг авахад хүргэсэн цус алдалт эсвэл халдвар

Зүрх судасны үйл ажиллагааны алдагдал

- **Дайрлага:** Цусны эргэлтийн хяналтын өөрчлөлт эсвэл эргэлдэх цусны эзэлхүүн буурсны улмаас захын цусны цочмог алдагдах байдал. Шингэн сэлбэлт хангалттай (>2Л) хийгдэж байсан ч ≥ 60 минутанд агшилтын цусны даралт <90 мм МУБӨ, судасны цохилт цөөндөө 120 байвал хүнд хэлбэрийн эмчлэгдэхгүй байгаа даралт бууралт гэж тодорхойлно.
- **Зүрх зогсох:** Зүрхний шахаж, татах үйл ажиллагаа гэнэт зогсож судасны цохилт тэмтрэгдэхгүй болох, ухаан алдах.
- **Хүнд хэлбэрийн гипоперфузи:** Эрхтнээр өнгөрөх цусны урсгал буурч, агааргүй замаар бодисын солилцоо явагдах, эсийн үйл ажиллагааны алдагдал, үхэлд хүргэх. Эхийн ноцтой хүндрэлийн хувьд лактат > 5 ммоль/Л буюу 45 мг/Л байх.
- **Хүнд хэлбэрийн хүчилшил:** Цус болон биеийн эдэд хүчил болон устөрөгчийн ихээр хуримтлагдах эсвэл бикарбонат буурснаас pH 7.1-ээс багасах.
- **Судас нарийсгагч эмийг үргэлжлүүлэн хэрэглэх:** Допамин, эпинефрин, норэпинефриныг ямар нэг тунгаар үргэлжлүүлэн хэрэглэх. Судас нарийсгагч эмийг үргэлжлүүлэн хэрэглэх гэдэг нь судас нарийсгагч эм агуулсан уусмалыг тасралтгүй дусаахыг хэлнэ.
- **Зүрх уушгины амилуулалт:** Зүрх зогсон байдлыг эмчлэх цээж шахалт болон уушгини агаар сэлгэлтийг багтаасан эмнэлгийн яаралтай тусламжийн ажилбарууд

Амьсгалын үйл ажиллагааны алдагдал

- **Цочмог хөхрөлт:** Цусны хүчилтөрөгчилт хангалтгүй болсны улмаас арьс болон салст бүрхэвч цочмогоор хөхөлбөр өнгөтэй болох
- **Таталдсан амьсгал /үхлийн өмнөх амьсгал/:** Эцсийн амьсгалын хэлбэр. Амьсгал таталдсан маягтай, авахад чимээтэй болох.
- **Хүнд хэлбэрийн амьсгал олшролт:** Маш түргэн амьсгалах буюу амьсгалын тоо минутанд 40-өөс олон гэж тодорхойлдог.
- **Хүнд хэлбэрийн амьсгал цөөрөлт:** Маш аажим амьсгалах буюу амьсгалын тоо минутанд 6-аас цөөн гэж тодорхойлдог.
- **Хүнд хэлбэрийн гипоксеми:** Цус болон эрхтнүүд дэх хүчилтөрөгчийн хэмжээ хүнд хэлбэрээр буурах буюу хүчилтөрөгчийн ханамж $< 90\%$ хэмжээтэй ≥ 60 минут байх эсвэл $\text{PaO}_2/\text{FiO}_2 < 200$ байх. $\text{PaO}_2/\text{FiO}_2$ үзүүлэлт нь артерийн цусны хүчилтөрөгчийн ханамж болон амьсгалж буй хүчилтөрөгчийн фракци хоёрын харьцаа юм. Артерийн цусны хүчилтөрөгчийн ханамжийг артерийн цусны хийн шинжилгээгээр тодорхойлно. Амьсгалж буй хүчилтөрөгчийн фракци нь өвчтний хэрэгцээнээс хамааран янз бүр байж болох ба хийн шинжилгээний дээж авах үеийн хэмжээг авч тооцно. Энэ нь тодорхой (жишээ нь зохиомол амьсгалуулалтын үед 0.21-1.00) эсвэл тооцоолсон (хүчилтөрөгч өгөөгүй үед 0.21, хамрын гуурсаар хүчилтөрөгч өгөх үед 0.25, хошуувчаар хүчилтөрөгчийн өгөх үед 0.25-1.00) байна.
- **Цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавьж амьсгалуулах:** Уушгинд агаар сэлгэлт хийх болон амьсгалын замыг чөлөөтэй байлгах зорилгоор цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавих

Бөөрний үйл ажиллагааны алдагдал

- **Шингэн сэлбэлт болон шээс хөөх эмэнд засрахгүй байгаа шээс багасалт:** Шингэн сэлбэлт болон шээс хөөх эм хэрэглэхэд 4 цагийн турш шээсний ялгаралт $< 30\text{мл/цаг}$ эсвэл $< 400\text{мл/24 цаг}$ байх.
- **Хүнд хэлбэрийн цочмог азотеми:** Цусанд азотын нэгдлүүд цочмогоор хэт их хуримтлагдах, креатинин $\geq 300\text{мкмоль/Л}$ эсвэл 3.5мг/дЛ байх.

- **Бөөрний цочмог дутмагшлын үеийн диализ эмчилгээ:** Цусны урсгалаас хаягдал бүтээгдэхүүндийг гемодиализ болон гялтангийн диализээр шүүж зайлцуулах.

Бүлэгнэлийн алдагдал

- **Цусны бүлэн үүсэхгүй байх:** бүлэн үүсгэх эмнэлзүйн чадваргүй байдал. Эмнэлзүйн хувьд судас хатгасан газарт эсвэл оёдол тавьсан нүхэнд бүлэн үүсэхгүй байх. Үүнийг орны дэргэдэх бүлэгнэлтийн сорилоор (7 минутын дараа бүлэн үүсэхгүй байх эсвэл амархан задрах зөөлөн бүлэн үүсэх нь бүлэгнэлтийн эмгэг байж болзошгүйг харуулна) эсвэл лабораторийн бусад үзүүлэлтээр (цочмог ялтын цөөрөл /<50,000 ялтас/, фибриноген багасалт /<1г/дЛ/, протромбины хугацааны уртсал />6сек, INR>5/, Д-димер ихсэлт />1000нг/дЛ/) үнэлж болно.
- **Хүнд хэлбэрийн цочмог ялтын цөөрөл:** Цусан дах ялтын тоо хэвийн бусаар буурч, <50,000/мл болох
- **Их хэмжээний сэлбэлт:** Цус эсвэл улаан эсийг ихээхэн хэмжээгээр /5 нэгжээс дээш цус эсвэл улаан эсийн бэлдмэл/ сэлбэх

Элэгний үйл ажиллагааны алдагдал

- **Манас таталтын урьдалтай үеийн шарлалт:** Манас таталтын урьдалтай үед гипербилирубинемийн улмаас арьс, склер, салст бүрхүүл болон ялгарлууд шарангуй өнгөтэй болох. Өмнө нь хэвийн цусны даралттай байсан нь тодорхой эмэгтэйчүүдэд даралт ихдэлт шээсээр уураг ялгарахтай хавсарсан байвал манас таталтын урьдал гэж тодорхойлно.
- **Хүнд хэлбэрийн цочмог гипербилирубинеми:** Цусан дах билирубин цочмог ихсэн, билирубин >100мкмоль/л эсвэл 6 мг/дЛ байх.

Мэдрэлийн үйл ажиллагааны алдагдал

- **Удаан хугацаагаар ухаангүй эсвэл дүгжраатай байх:** 12 цагаас илүү хугацаагаар ухаангүй байх. Гадны цоччуулд хариулт үзүүлэх нь бүрэн эсвэл бараг бүрэн хэмжээгээр алдагдсан ухамсарт ухааны гунзгий өөрчлөлтийг ухаан алдалт гэж тодорхойлно. Глазгогийн комын оноо <10 байх байдалтай тохирно.
- **Цус харвалт:** тархины судасны шалтгаанаар 24 цагаас илүү хугацаагаар үргэлжлэх эсвэл 24 цагийн дотор нас баралтаар төгсөх мэдрэлийн дутмагшилтай байдал.
- **Хянагдахгүй байгаа таталт:** Тархи үргэлжилсэн таталтын байдалд байх байдал. Намдахгүй, үргэлжилж байгаа таталт.
- **Эпилепсийн байдал:** 30-аас дээш минутын турш үргэлжлэх нэг удаагийн зогсолтгүй таталт эсвэл таталт хооронд ухаан сэргэхгүйгээр 30 минутаас дээш хугацаанд давтан таталт.
- **Тархмал саажилт:** Биеийн хоёр талын бүрэн эсвэл хэсэгчилсэн саажилт. Хэт их мэдрэл-булчингийн тархмал саажилт нь үргэлж амь тэнссэн өвчинтэй холбоотой байдаг. Амь тэнссэн өвчин нь полиневромиопати.

Умайн үйл ажиллагааны алдагдал

- **Умайг авахад хүргэсэн умайн халдварт эсвэл цус алдалт:** Эхийн ноцтой хүндрэлийн хувьд халдварт эсвэл цус алдалтын улмаас умайг мэс заслын аргаар авах.

Хоёр. Үйл ажиллагаа

2.1. Тухайн эмнэлгийн дарга, эмнэлгийн чанарын менежер, эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмч, холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамtran тухайн сарын ноцтой хүндрэлийн тохиолдлын холбогдох материалтай танилцаж, доорх асуудлыг хэлэлцэнэ:

- Тухайн тохиолдол нь эхийн ноцтой хүндрэл мөн эсэхийг нягтална;
- Эхийн ноцтой хүндрэлийн шалтгааныг тогтооно;
- Нөлөөлсөн хожимдлыг тодорхойлно;
- Уг хожимдлыг арилгахаар хэрэгжүүлэх ажлын талаар шийдвэр гаргана;
- Оролцогчид харилцан ярилцаж, санал гаргана;
- Оношлогоо, эмчилгээтэй холбоотой сургамж, дүгнэлтийг хийнэ;
- Эхийн эндэгдлийн картыг хамtran бөглөнө;
- Хурлаас зөвлөмж, шийдвэр гаргана;
- Гарсан сургамж, зөвлөмж, шийдвэрийг холбогдох байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулна.
- Ноцтой хүндрэлийн тохиолдлын “Жирэмсэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийг бүртгэх маяг” /хавсралт-3/-ыг бөглөж, хурлын зөвлөмж, шийдвэрийн хамт Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд дараа улирлын эхний сарын 05-ны дотор ирүүлнэ.

2.2. Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн яамны эх барих эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамtran жирэмсэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийн тохиолдолд дүн шинжилгээ хийж, Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн хурлаар дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан хэлэлцүүлнэ.

оо О оо

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 7 дугаар сарын 6.
өдрийн 29 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ЖИРЭМСЭЛТ, ТӨРӨЛТ, ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН НОЦТОЙ ХҮНДРЭЛИЙГ БҮРТГЭХ МАЯГТ

Жирэмсэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийг бүртгэх маягт										Хувь хүний асуумж манжт																											
										худас 1/2																											
Танилцуулга <p>Энэ маят нь хэсгүүдээс бүрдэн. Хэсэг бүр өвөрмөц зорилтот бүлэгт зориулагдсан. Хувь хүний асуултанд зарим хэсэг бэлгэдэгчүү алгасаж болно. Хэрээ мэдээлэл тодорхой биш бөх гэж багасна.</p> <p>Асуумж 35, 36 нь судалгааны гол онилог хэсэг. Эргэлээтэй байвал, оролцсон эмчтэй ЗӨВЛӨ</p> <p>Хэрэв ижр төрөлт бол, Асуулт 1 болон 19- 31 бичсэн нэмэлт хуудас баглене.</p>																																					
A Бүх эмчтэ																																					
<p>1. Бүртгэлий №:</p> <p>a) Аймгийн код b) Байгууллагын код c) Төрөлтийн/өвчиний түүхийн дугаар</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr><td>ө</td><td>ө</td><td>с</td><td>с</td><td>он</td><td>он</td><td>он</td><td>он</td></tr> </table> <p>2. Эмчилгэтийн огноо</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr><td>ө</td><td>ө</td><td>с</td><td>с</td><td>он</td><td>он</td><td>он</td><td>он</td></tr> </table> <p>3. Эмчилгээ гарсан болон нас барсан огноо</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr><td>ө</td><td>ө</td><td>с</td><td>с</td><td>он</td><td>он</td><td>он</td><td>он</td></tr> </table> <p>4. Нас (түүндэш шисиг бичнэ)</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr><td> </td><td> </td></tr> </table> <p>5. Гэр бүлүүн байцаал</p> <p>1= Ганц Тусдаа амьдардаг/Салсан/Бэлбэсэн/бусад 2= Гэрэлзэн/хамтран амьдрагч</p>												ө	ө	с	с	он	он	он	он	ө	ө	с	с	он	он	он	он	ө	ө	с	с	он	он	он	он		
ө	ө	с	с	он	он	он	он																														
ө	ө	с	с	он	он	он	он																														
ө	ө	с	с	он	он	он	он																														
<p>6. Эмчилгэтийн боловсрол бага-1, дунд-2, МБТБ-3 дээд-4, боловсролтуй-5</p> <p>7. Жирэмсэлтийн тоо (доогуйн жирэмсэлтийг оролцуулна)</p> <p>8.Өмнөх төрөлтийн тоо (доогуйн жирэмсийн тегсгэл оруулжгүй)</p> <p>9. Өмнөх кесаро хагалгааны тоо</p> <p>10 Өмнө нь дутуу төрж байсан Өмнө нь зулбаж байсан,</p> <p>11. Жирэмсэлт, төрөлт, төрсний дараах болон үр хөндөлтгэй холбоотой ямар нэгэн хүндрэл байсан уу (1=Үгүй 2=Тийм)</p> <p>12. Эмчилгээ гарах үеийн хийбн амь насны байдал 1= Амьдарсан 2= Нас барсан</p> <p>13. Эмчилгэтийн 1= төрсөн, 2= үр хөндүүлсэн, 3= зулбасан</p>																																					
B1 Төрсөн эсвэл үр хөндүүлсэн эмчтэй																																					
<p>14. Төрсөн болон үр хөндүүлсэн өдөр</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr><td>ө</td><td>ө</td><td>с</td><td>с</td><td>он</td><td>он</td><td>он</td><td>он</td></tr> </table> <p>15. Аль нэг эмчилгэтийн байгууллагад ирхээс өмнө төрсөн/зулбасан (үр хөндүүлсэн) үү? (1=Тийм 2=Үгүй)</p> <p>16. Төрөлт/үр хөндөлтийн ажилбарыг тодорхой бичих: 1= Төрөх замаар 8= Вакум таталт 2= Кесарохагалгаа 9= Эх барикын хавччур</p> <p>3= Умайн гаднах жирэмсэн хэвлэлийгээр мэс засал хийгдсэн 4= Мэс засал болон эмийн арга хөргөлзүүгүй үр хөндөлт (5-7) 5= Эмийн аргаар үр хөндүүлж, умайн хөндийг хөослох 6= Умайн хөндийгээс соруулах 10= Мэдэхгүй 7= Умайн хөндийг хусах</p> <p>17. Төрөх болон үр хөндүүлж үеийн жирэмсийн хугацаа?</p> <p>18. Төрөх/үр хөндөх үед эмчилгээд ямар нэгэн эмчилгээ хийсэн үү? (1=Тийм 2=Үгүй)</p> <p>a) Төрсний дараах цус алдалтаас соргийтийн окситоции b) Төрсний дараах цус алдалтаас соргийтийн мизопростол c) Төрсний дараах цус алдалтаас соргийтийн эрготами d) Төрсний дараах цус алдалтаас соргийтийн умай аглаахаа бусад эм e) Кесар хагалгааны үед антибиотик урьдчилсан соргийн f) Ерөнхий мэдээгүйжүүлэг g) Эпидурал мэдээгүйжүүлэг h) Нугасны мэдээгүйжүүлэг</p>												ө	ө	с	с	он	он	он	он																		
ө	ө	с	с	он	он	он	он																														
B2 Төрөх замаар эсвэл кесаро хагалгаагаар төрсөн эх (Q15=1 эсвэл 2 эсвэл 8)																																					
<p>19. Энэ төрөлтөөр хэдэн амьд хүүхэд төрүүлсэн бэ?</p> <p>20. Ихэр бол амьд нярайн төрсөн дараалал (1 дахь, 2 дахь, 3 дахь)</p> <p>21. Төрөлтийн эхэлэл 1= аяндаа 2= сэдээссэн 3= төрөлт явагдаагүй</p> <p>22. Төрөх үеийн ургийн түрүүлсэн хэсэг (1=тогтол 2=аарцаг 3=бусад)</p> <p>23. Нярайн хүйс (1= Эм 2= Эр)</p> <p>24. Нярайн төрөх үеийн жин (гр)</p> <p>25. Төрөх үеийн нярайн эрүүл мэндийн байдал a) Амьдын шинж (1= Амьд 2=Дэвтэж амьгүй болсон 3=Арьс зүйлгарсан амьгүй ураг) b) 5 минутын дотор Аялгарын оноо</p> <p>26. Нярайц ямар нэгэн хүндрэл зөвнүүр байсан уу? (1=Тийм 2=Үгүй)</p> <p>27. Нярайт эрчимтэй эмчилгээний/ өвөрмөц тусламж шаардлагатай тасаг нэгжийн хүлээн авсан уу? (1=Тийм 2=Үгүй)</p> <p>28. Эмчилгээ гаралгүй байгаа бол эхний 7 хоног дахь нярайн байдал 1 = Амьд 2 = Нас барсан</p> <p>29. Нярайн эмчилгээ гарсан/шилжүүлсэн/ нас барсан огноо</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr><td>ө</td><td>ө</td><td>с</td><td>с</td><td>он</td><td>он</td><td>он</td><td>он</td></tr> </table>												ө	ө	с	с	он	он	он	он																		
ө	ө	с	с	он	он	он	он																														

C	Хүндрэлтэй нарайд (Q26=2 эсвэл Q27=2 эсвэл Q28=2)	<p>30. Эмнэлэгт байх үед болон амьдралын эхний 7 хоногт нарайд ямар нэгэн эмчилгээ хийгдсэн ё? (1=Үгүй 2=Тийм)</p> <p>a) Интубаци тавьсан (термегц/амьдралын эхний 7 хоногийн аль нэг үед) <input type="checkbox"/></p> <p>b) Хамрын ЦПАП <input type="checkbox"/></p> <p>c) Сурфактант хэрэглэсэн <input type="checkbox"/></p> <p>d) Амьсгал зүрхний сэхээн амьдруулалт(зүрхний илтэг) <input type="checkbox"/></p> <p>e) Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих эм <input type="checkbox"/></p> <p>f) Таталтын эсрэг эм хэрэглэсэн <input type="checkbox"/></p> <p>g) Эхний 24 цагийн дотор фотоэмчилгээ хийгдсэн <input type="checkbox"/></p> <p>h) Цус цусан бүтээгдэхүүн хэрэглэсэн <input type="checkbox"/></p> <p>i) Гипогликеми эмчилэх стериод хэрэглэсэн <input type="checkbox"/></p> <p>j) Судсаар антибиотик эмчилгээ хийсэн <input type="checkbox"/></p> <p>k) Ямар нэгэн мэс ажилбар <input type="checkbox"/></p>	<p>31. Төрөлтийн гэмтэл a) тархины цус харвалт b) ус мөчний гэмтэл c) бусад</p> <p>32. Эмнэлэгээс гарахын өмнө нарайд ямар нэгэн гажиг оношилждсон ў? (1=Үгүй 2=Тийм) <input type="checkbox"/></p> <p>33. Хэрэв Q30=2 гэсэн бол ямар гажиг болохайт тодорхой бич (1=Үгүй 2=Тийм)</p> <p>a) Нугас, тархи, төв мэдрэлтийн тогтолцооны <input type="checkbox"/></p> <p>b) Уруул/сэтгэхий/ тагнайгүй <input type="checkbox"/></p> <p>c) Зүрхний <input type="checkbox"/></p> <p>d) Беерний <input type="checkbox"/></p> <p>e) Мечийн <input type="checkbox"/></p> <p>f) Хромосомын өөрчлөлт (Дауны хамшинок) <input type="checkbox"/></p> <p>g) Харагдах жижиг гажиг, өөрчлөлтүүд <input type="checkbox"/></p> <p>h) Бусад 34 Ургийн халдварт <input type="checkbox"/></p>
	35. Кесаро хагалгааны заалт		
	36. Бусад мэс засал хийсэн заалт		
	37. Яаралтай тусламж үзүүлсэн хугацаа		
D	Дутуу төрсөн эмзгээ (Q16<37 долоо хоногтой)	<p>37. Одоо эмнэлэгт байгаа бол байдлыг тодорхой бич (1=Үгүй 2=Тийм)</p> <p>a) Эмнэлэгт ирээд эхний 3 цаг дотор төрөх замаар төрсөн <input type="checkbox"/></p> <p>b) Кортикостеройд хэрэглэсэн <input type="checkbox"/></p> <p>c) Кесаро хагалгаагаар төрүүлсэн <input type="checkbox"/></p> <p>d) Ураг орчмын шигэгэн цагас зуртаж гарсан <input type="checkbox"/></p> <p>e) Нярай халдвартай <input type="checkbox"/></p>	<p>f) Дутуу төрхөөс сэргийлэх эмчилгээ: 1) Бетаминетикуүд (terbutaline, ritodrine... гэх мэт) 2) NSAIDS / Кокс-инхибиторууд (индометацин... гэх мэт) 3) Кальций блокаторууд(нифебилин...гэх мэт) 4) Окситоцины серег эм (атосибан) 5) Магни сульфат 6) Хэвтрэйд дэглэм 7) Шингэн нөхөх (NaCl 0.9%) Hydration 8) Дутуу төрлөөс сэргийлэх эмчилгээ хийгдээгүй <input type="checkbox"/></p>
E	Хүндрэлтэй (Q12=2) эсвэл нас барсан эмзгээ (Q12=3)	<p>38. Ямар хүндрэл байсан бэ?</p> <p>Цус алдалт (1=Үгүй 2=Тийм)</p> <p>a) Үр хөндөлтийн улмаас цус алдсан <input type="checkbox"/></p> <p>b) Умай гаднах жирэмсэн <input type="checkbox"/></p> <p>c) Ихэс төвлөө байрлах <input type="checkbox"/></p> <p>d) Ихэс шигдэх <input type="checkbox"/></p> <p>e) Ихэс хөвхрох <input type="checkbox"/></p> <p>f) Умай урагдсан <input type="checkbox"/></p> <p>g) Төрсний дараах цус алдалт <input type="checkbox"/></p> <p>h) Эх барихын бусад цус алдалт <input type="checkbox"/></p> <p>i) Ихэс саатсан <input type="checkbox"/></p> <p>j) Умай урвах <input type="checkbox"/></p> <p>k) Үр хөндөлтийн улмаас умай цоорох <input type="checkbox"/></p> <p>Халдварт j) Үр хөндөлтийн холбоотой <input type="checkbox"/> k) Төрөх үеийн умайн салстын үрэвсэл <input type="checkbox"/> l) Пиелонефрит <input type="checkbox"/> m) Томуу тест өвчин <input type="checkbox"/> n) Бусад системийн халдварт үрэвсэл/үжил <input type="checkbox"/> </p> <p>Дараалт ихслэл o) Архаг дараалт ихслэх өвчин <input type="checkbox"/> p) Манас таталтын үртэл (манас таталт орохгүй) <input type="checkbox"/> q) Манас таталт <input type="checkbox"/> </p> <p>Бусад эмзгэг өвчинүүд r) ХДХВ+/ДОХ /ХДХВ-ийн хамшинж <input type="checkbox"/> s) Цус багадалт <input type="checkbox"/> t) Хумхгаа / шавьжаар хатгуулж үүссэн энцефалит <input type="checkbox"/> u) Эмболи (бүлэн/ураг орчмын шигтэн/хийн эмболи) <input type="checkbox"/> v) Хавдар <input type="checkbox"/> w) Зүрхний өвчин <input type="checkbox"/> x) Ушгийн өвчин <input type="checkbox"/> y) Беерний өвчин <input type="checkbox"/> z) Эзгийн өвчин <input type="checkbox"/> ii) Золгүй нөхчүүчирхийлэл, осол, амиа хорлох <input type="checkbox"/> iii) Нүдний эмзгэг <input type="checkbox"/> iv) Дотоод шүүгчлийн эмзгэг <input type="checkbox"/> </p>	<p>35. Эх нас барсан эсвэл хүндэрсн тохиолдолд тодруулна</p> <p>Ямар эмзгэг өвчин болохыг тодорхойлно: (1=Үгүй 2=Тийм)</p> <p>Зүрх-судасны үйл ажиллагааны алдагдал</p> <p>a) Шок <input type="checkbox"/></p> <p>b) Зүрх зогссон <input type="checkbox"/></p> <p>c) Цусны эргэлтийн алдагдал (lactate >5 mmol/L or >45mg/dL) <input type="checkbox"/></p> <p>d) Хүнд хэлбэрэйн ашиглоз (pH<7.1) <input type="checkbox"/></p> <p>e) Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих эмчилгээ хийгдсэн <input type="checkbox"/></p> <p>f) Амьсгал зүрхийг сэхэн амьдруулах <input type="checkbox"/></p> <p>Амьсгалын эрхтний үйл ажиллагааны алдагдал</p> <p>g) Хурц цианоз <input type="checkbox"/></p> <p>h) Гаслинг амьстгал <input type="checkbox"/></p> <p>i) Хүнд тахилное (амьсгал нэг минутанд > 40 олон) <input type="checkbox"/></p> <p>j) Хүнд брадицисеа(амьсгал нэг минутанд < б цөөн) <input type="checkbox"/></p> <p>k) Хүнд гипоксеми (O2 сатурации <90% for ≥60min or PAO2/FiO2<200) <input type="checkbox"/></p> <p>l) Унтуулгатай хамааралгүйгээр зохиомол амьсгал интубаци хийгдсэн <input type="checkbox"/></p> <p>Беерний үйл ажиллагааны алдагдал</p> <p>m) Шингэн сэлбэлт эсвэл шээх хөөх эмчилгээнд үр дүнгүй шээс багасах <input type="checkbox"/></p> <p>n) Хүнд хэлбэрэйн хурц азотеми (креатинин>300umol/ml эсвэл >3.5mg/dL) <input type="checkbox"/></p> <p>o) Беерний хурц дутагдлын улмаас диалез хийгдсэн <input type="checkbox"/></p> <p>Диалез</p> <p>p) Бүлэгнэлт алдагдсан <input type="checkbox"/></p> <p>q) Хүнд хурц тромбоцитопени ($<50,000$ тромбоцит/мл) <input type="checkbox"/></p> <p>r) Цус болон улсан эс ихээр нөхсөн(≥ 5 нэгж) <input type="checkbox"/></p> <p>Эзгийн үйл ажиллагааны алдагдал</p> <p>s) Манас таталтын үрдлаас арьс шарласан <input type="checkbox"/></p> <p>t) Хүнд хэлбэрэйн хурц гипербилирубинеми (билирубин>100umol/L эсвэл >6.0mg/dL) <input type="checkbox"/></p>

66

34. Эмэгтэйд ямар нэгэн эмчилгээ хийгдсэн бол тодорхой бичих:
(1=Үгүй 2=Тийм)

Цус алдалт

- a) Төрсний дараах цус алдалгаас сэргийлэх окситошин
- b) Төрсний дараах цус алдалгаас сэргийлэх мизопростол
- c) Төрсний дараах цус алдалгаас сэргийлэх эрготами
- d) Төрсний дараах цус алдалгаас сэргийлэх умай аглааах бусад эмүүд
- e) Артерийн судсмыг боосон/эмболизаци хийсэн
- f) Баллон болон чиосс тавьсан
- g) умайш цус тогтоох шахах оёдол тавьсан

Халдвэр

- g) Судсаар антибиотик эмчилгээ хийсэн
(урьдчилан сэргийлэх эмчилгээг оруулнахгүй)

Дараалт ихслэлт

- h) Манас таталтын эсрэг магни сульфат тавьсан
- i) Манас таталтын эсрэг бусад эм хэрэглэсэн

Бусад эмчилгээ

- j) Ихсний үлдэгдлийг авсан
- k) Ихэс гардсан
- l) Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэн
- m) Хэзлийн эзэсн
- n) Эрчимт эмчилгээний тасагт хүлээн авсан

Мэдрэлийн ўйл ажиллагчны алдагдал

- u) Ухаангүй эсвэл комын байдалд удсан (>12 цагаас дээш үргэлжилсэн)
- v) Цус харласан
- w) Ухаангүй /эшилэпсийн статуст орсон
- x) Ерөнхий паралич

Умайин ўйл ажиллагчны алдагдал

- y) цус алдалт болон халдварьн улмаас умай авагдсан

35. Эмзилэгт ирэх үеийн биеийн байдлыг тодорхой бич: (1=Үгүй 2=Тийм)

- a) Эмзилэгт ирэх үед эсвэл эмзилэгт хэвтсэн эхний 24 цагийн дотор Q35 зүйл нэг шивж байсан

- b) Эмэгтэй эмзилэгт ирэх үедээ болон эмзилэгт ирээд эхний 24 цаг дотор нас барсан

36. Шилжүүлгийн талаар тодорхой бичнэ: (1=Үгүй 2=Тийм)

- a) Эмэгтэй аль нэг эмзилэгээ шилжжик ирсэн

- b) Эмэгтэй дээд шатлалын аль нэг эмзилэгт шилжжэн

37. Хэрэээ эмэгтэй үр хөндөх/терехөөс өмнө нас барсан эсвэл эмзилгээс гарах үед жирэмсэн үргэлжлилж байгаа

болов гарах болон нас барсан үеийн жирэмсний хугацааг тодорхой бич (жирэмсний хугацааг бутэн долоо хоногийр бичнэ)

АСУУЛАЖ АВСАН ТА НААРХ МЭДЭЭЛЭЛ

Мэдээлэл авсан өдөр	
ө	ө
с	с
он	он
он	он
он	он

Мэдээлэл цуглуулагчийн иэр

Гарын үсэг